

**ГХБХБГ-ЫН 6 ДУГААР САРЫН ЭХНИЙ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ,
СУДАЛГАА**

2018.06.07.

ӨЛГИЙ СУМ

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>Аймгийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 05–ны өдрийн А/411 тоот захирамжаар Нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан 35 иргэнд 37156 м2 газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсэн.</p> <p>Газар өмчлөх эрхийг дуусгавар болгож нийтийн орон сууцны зориулалтаар газар эзэмшихийг хүссэн 1 иргэнд аймгийн Засаг даргын захирамжийн дагуу газрын гэрчилгээ олгож гэрээ байгуулж мэдээллийн санд оруулав.</p> <p>Мөн газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хүссэн 2 иргэнд гэрчилгээ олгож бүртгэв.</p> <p>Алтай сумын газрын даамлын үйлдсэн 6, Алтанцөгц сумын газрын даамлын үйлдсэн 18 нэгж талбарын зургийг хянаж кадастрын өөрчлөлтийг дуусгавар болгож өгөв.</p> <p>Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн албан бичгийн дагуу 1 иргэний эзэмшиж байгаа газрын талаарх лавлагааг гаргаж хүргүүлэв.</p> <p>Хадгаламж банк ХХК-ний эрх хүлээн авагчаас ирүүлсэн албан тоотын дагуу лавлагаа гаргаж хүргүүлэв.</p> <p>Эзэмшил газрын гарц шийдвэрлүүлэх тухай ирүүлсэн албан бичгийн дагуу газар дээр нь очиж шийдвэрлэж хариу өгөв.</p> <p>“Өлгий ланд” ХХК-ний Өлгий сумын төвд хийж гүйцэтгэсэн 19 газрын хэмжилтийн зургийг хүлээн авч газрын кадастрын мэдээллийн санд оруулав.</p> <p>Сумдын газрын даамлуудаас тогтмол 7 хоногийн мэдээ авч</p>	<p>Шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бичиг, өргөдлийг шийдвэрлэх</p>	

ажиллаж байна. **Тухайлбал:**

Алтай сум: Өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмших өргөдөл хүсэлтийг хүлээн авч, Өргөдөл хүсэлтийг хянан үзэж 5 иргэнд засаг даргын захирамж гаргуулж шийдвэрийг үндэслэн газар эзэмших гэрээ байгуулж гэрчилгээ олгов.

Алтанцөгц сум: Энэ долоо хоногт эзэмшилд хоёр захирамж төлөвлөн Засаг даргад танилцуулж батлуулав.

- ✓ Хоёр иргэнд гэрээ, хийж гэрчилгээ олгов.
- ✓ Нэг өвөлжөөний координат авч ЛМ-д оруулж түр нэгж талбар үүсгэв.
- ✓ ARC GIS-д 84 өвөлжөө, хаваржаа бүртгэж 3-р багийг дуусгав.
- ✓ Засаг даргад хоёр захирамж төлөвлөн өгч батлуулав.
- ✓ Засаг даргын өрөөнд хуралд орж багийн Засаг дарга нарт зөвлөгөө өгч багийн хурлаас ГЗБ-ийн төлөвлөгөөний санал авах, багийн хил тогтох, хадлан ашиглалтын талаар санал авч ажил зохион байгуулахыг хэлэв.
- ✓ 2-р багийн ИНХ-д оролцож ГЗБ-гийн төлөвлөгөөнд санал авч, багийн хилийн талаар ойлголт өгсөн боловч иргэд дэмжихгүй байна.

Толбо сум: Энэ 7 хоногт Чайна Хуаши интетпрайзиз ХХК-ний шинээр баригдаж байгаа замд шороо карьер авсан газарт очиж хяналт хийж ирэв. Мөн 2 иргэнээс өргөдөл хүлээн авч ажиллаж байна.

Дэлүүн сум: Энэ долоо хоногт Геодезийн цэг тэмдэгтийн тооллогын ажлын Сумын 3,1,6-р багийн нутаг дэвсгэрт байгаа цэгийн зургийг авч ирсэн болно. Мөн 2019 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал авч газрын төлбөрийг хурааж ирсэн болно.

Ногооннуур сум: 5 иргэний өргөдөл хүлээж авав Сумын төвөөс 1 иргэний газрыг газар дээр нь тодруулсан.